

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журам гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Төрийн захиргааны албаны зөвлөлийн 1997 оны 15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолыг төрийн бүх байгууллагуудад хүргүүлэн танилцуулж, хэрэгжүүлэхийг Ажлын албаны дарга Ц.Самбаллхүндэвт даалгасугай.

ДАРГА

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

**“ТӨРИЙН АЛБАНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”
цол, тэмдгээр шагнах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх, санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан төрийн албан хаагчийг Төрийн албаны зөвлөл /цаашид “Зөвлөл”гэх/-ийн “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагнал олгох болзол

2.1.Шагналд нэр дэвшигч нь дор дурдсан болзлыг хангасан байна.

Үүнд:

а)Төрийн албан тушаалд 15-аас доошгүй жил үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж, тухайн хугацаанд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн хувьд тогтвортой өндөр үнэлгээ авсан байх;

б)Төрийн албаны өмнө тавигдсан зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан байх;

в)Монгол Улсын хууль, төр, засгийн бодлого, шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэхэд тодорхой үр дүн гаргасан байх;

г)Төрийн албаны соёл, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх, энэ талаар үлгэрлэгч байх.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох журам

3.1.Уг шагналыг Үндэсний их баяр наадам болон Бүгд Найрамдах Улс тунхагласны баярыг тохиолдуулан олгоно.

3.2.Энэ журмын хоёр дахь хэсэгт заасан болзлыг хангасан гэж үзсэн төрийн албан хаагчийг шагналд нэр дэвшүүлэх санаачилгыг тухайн нэр дэвшигчийн ажиллаж байсан, эсвэл одоо ажиллаж байгаа үндсэн байгууллага нь гаргана.

3.3.Шагналд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолтод шагнуулах үндэслэлийг тодорхой тусгах бөгөөд шаардлагатай бол холбогдох баримтыг хавсарган ирүүлж болно.

3.4.Шагналд нэр дэвшүүлэх тухай холбогдох яамны дэргэдэх болон аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.5.Шагналд нэр дэвшигчийн талаарх санал, тодорхойлолтыг дараах байгууллага, албан тушаалтан Төрийн албаны зөвлөлд уламжилна. Үүнд:

а) Яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь яамны

болон Засгийн газрын агентлаг, харъяа байгууллагын албан хаагчийн;

б) Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь бүх

шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга болон төрийн бусад албан хаагчийн;

в) УИХ-ын Байнгын хороо нь УИХ-ын гишүүний;

г) Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Ерөнхийлөгчийн зөвлөх, Тамгын газрын ажилтны;

д) УИХ-ын Тамгын газар нь УИХ-ын даргын зөвлөх, ажлын албаны болон

Тамгын газрын албан хаагчийн;

е) Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Ерөнхий сайд, Засгийн газрын

гишүүн, тэргүүн шадар сайд, шадар сайд, тэдгээрийн зөвлөх, ажлын албаны болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, төрийн бусад албан хаагчийн ;

ж) Төсвийн Ерөнхийлөн захирагч нь УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын албан хаагчийн;

з) Улсын Ерөнхий прокурор нь бүх шатны прокурор, прокурорын байгууллагын албан хаагчийн;

и) Шүүхийн зөвлөлийн дарга нь бүх шатны шүүгч, шүүхийн байгууллагын албан хаагчийн;

к) Төрийн албаны зөвлөлийн дарга нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд,

Зөвлөлийн бүтцийн нэгжийн албан хаагчийн;

л/ Төрийн албаны зөвлөл нь өөрийн санаачилгаар нэр дэвшүүлсэн албан хаагчийн.

3.6. Шагналд нэр дэвшигчийн талаар энэ журмын 3.2, 3.3, 3.4-д заасны дагуу бүрдүүлж ирүүлсэн материалыг Зөвлөлийн Ажлын алба хүлээн авч судлан Зөвлөлийн хуралдаанд саналаа танилцуулна. Уг саналаа Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шагнах тухай

Зөвлөлийн шийдвэрийг Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар баталгаажуулна.

3.7.Шагналыг энэ журмын 3.5-д заасан шагналд нэр дэвшүүлж, санал, тодорхойлолт гаргах эрх бүхий албан тушаалтан ёслол хүндэтгэлийг баримтлан гардуулна.

Дөрөв. Шагналын баталгаа, дагалдах мөнгөн шагнал

4.1.Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгийн гэрчилгээнд Төрийн албаны зөвлөлийн дарга гарын үсэг зурах бөгөөд тамга дарж баталгаажуулсан байна.

4.2.“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнагдсан төрийн албан хаагчид тухайн байгууллага нь 100.000/ нэг зуун мянган/ төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгоно.

--- оОо ---

Загвар

**“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр
шагнуулах нэр дэвшигчийн тодорхойлолт**

200... оны . . дугаар сарын өдөр

Зураг
4x6

1.Овог, нэр

2.Төрсөн он

3.Регистрийн дугаар

4.Эрэгтэй, эмэгтэй

5.Хэдээс хэдэн онд хаана, ямар сургууль төгссөн, боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол.

6.Үндсэн захиргаа

7.Эрхэлж байсан ажил, албан тушаал /ажилд анх орсноосоо эхлэн он дарааллаар нь бичнэ/:

8.Улсад ажилласан нийт хугацаа____/жил/, үүнээс төрийн албанд____жил, тухайн албан тушаалд____жил

9.Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Зэрэг дэв:

10.Төр, Засгийн ямар шагналаар хэзээ шагнагдсан:

11.Бусад ямар шагналаар шагнагдсан:

12.Одоо шагнуулах гэж буй үндэслэл: / Яам, агентлаг, төрийн холбогдох бусад болон нутгийн захиргааны байгууллагын өмнө тавигдсан төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд оруулсан бодит хувь нэмэр, мэргэшлийн өндөр түвшинд боловсруулсан чухал асуудал, зөвлөмж, төр засгийн хууль, бодлого, шийдвэрийг сурталчилж хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын тодорхой үр дүн зэргийг тусгана. Мөн тухайн хүний ажлын гол үзүүлэлт, түүний үр дүн /үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ /-г хавсаргаж болно.

13.Төрийн албан хаагчийн сахилга, ёс зүйн хэм хэмжээний талаар зөрчилтэй эсэхийг шалгаж, магадалсан байна.

14.Үндсэн байгууллага, нэгжийн саналын үндэслэл:
(Үндсэн байгууллагын дарга, захирал, эрхлэгч гарын үсэг зурж, тэмдэг дарна)

15.Шагналд нэр дэвшигчийг Төрийн албаны зөвлөлд уламжилсан байгууллага, албан тушаалтны санал, тодорхойлолт (Гарын үсэг, тамга, тэмдэг дарна)

-----oOo-----